

ХЯТАД ХЭЛ СУРАХ ЯВЦАД ГАРГАЖ БУЙ АЛДААГ СУРГАЛТЫН ИДЭВХТЭЙ АРГААР БАГАСГАХ БОЛОМЖ

Т.Энэбиш
Ховд Их Сургууль
Eenee_osxoo@yahoo.com

Хураангуй

Хүний хэл сурах үйлдэл нь үндсэндээ алдаа гаргахтай байнга холбогдож байдаг үйл явц юм. Алдаа, буруу дүгнэх, буруу тооцоолох, буруу ташаа таамаглах зэрэг нь үнэн хэрэгтээ мэдээлэл авах, эсвэл ямар нэгэн чадвар эзэмших асуудлын чухал тал юм. Хоёр дах хэл сурах нь оролдлого болон алдаа бүхий мөн чанараараа анх хэл сурахаас ялгаатай. Хятад хэл эзэмших явцдаа суралцагчид алдаа гаргах нь зайлшгүй бөгөөд хэрэв суралцагч алдаа гаргахгүй, алдаанаасаа суралцахгүй байвал сурах үйл удааширдаг байна.

Түлхүүр үг: Заах арга, суралцагч төвтэй сургалт, гадаад хэл эзэмших үйл явц

Оршил: Хятад хэлийг сурч ажил мэргэжил бизнесдээ ашиглах нь манай орны хувьд зайлшгүй хэрэгцээ шаардлага байна. Гадаад хэлний мэдлэг бол хүний сэтгэлгээг тэлж, хөгжүүлж байдаг тул гадаад хэлийг сурч сургахдаа прагматик хэрэглээтэй холбох асуудал чухал болж байна. Шинжлэх ухааны доктор, профессор Д.Нямжав “Гадаад хэл сурч эзэмших сэтгэлзүйн зарим асуудалд” бүтээлдээ “Гадаад хэл сурч/эзэмших оюутан сурагчдын амжилт нь оюуны эрч хүчээ дайчлан гадаад хэл эзэмших хэрэгцээ, сонирхол, сэдэл тэмүүлэл, үйл ажиллагааны үр дүнгээс ихээхэн нөлөөлдөг болох нь олон жилийн туршилт сургалтаар нотлогдож байгаа юм. Тухайлбал, гадаад хэлээр илтгэл, сонсгол бэлтгэх, хоёр талын орчуулга хийх, илтгэх урлагийн арга барил эзэмших, дуу шүлэг тогтоох, уралдаан тэмцээнд оролцох зэрэг үйл ажиллагаанд зарим оюутан сурагчид оролцож амжилтанд хүрч гадаад хэл эзэмших танин мэдэх хэрэглээний сэдэл тэмүүлэлтэй болсоор байгаа билээ...” хэмээн тэмдэглэсэн байна.

Хятад хэлний нэрт орчуулагч, хэл судлаач Д.Болдбаатар “Гадаад хэл төгс сурахуйн нууц” номондоо “Гадаад хэл сурахын тулд өдрийн зөв дэгийг баримталж, амжилттай сурахын төлөө сэтгэл санаагаа төвлөрүүлэх, элдэв дэмий зүйл бодож толгойгоо бүү гашилгах. Тухайн өдөр үзсэн сэдвийг олон дахин унших. Олон дахин хуулан бичих. Илүү гарсан чөлөөт цагийг ашиглах хэл сурна гэдэг зүлэг тарихтай адил тул хэт ачаалалгүй зугуухан тогтмол ажиллах багшид бус өөртэйгээ ажиллах, Гадаад хэл сурна гэдэг нь хэлнийхээ хүрээнээс хальж шинэ хэл, шинэ соёл, шинэ сэтгэлгээ, мэдрэмж, үйлдлийн өөр ертөнцөд нэвтрэн орно гэсэн үг юм.

Үндсэн хэсэг:

Судлаачдын хувьд суралцагчийн алдаа гаргах байдлыг эх хэлний нөлөөнөөс, сурч буй хэлний системийн нөлөөнөөс, суралцагчийн сурч буй хэлээ сурах дотоод механизм буй интер хэлний нөлөө гэсэн ерөнхий гурван хүчин зүйлийн нөлөөлөл дээр судалгаагаа явуулж харилцан бие биеэ хүлээн зөвшөөрөх хандлага ажиглагдаж байна. Суралцагч эх хэлнийхээ авиа зүйн тогтолцоотой уялдуулан гадаад хэлийг сурдаг.

Харин өгүүлбэр зүй нь суралцагчийн авиа зүйн нөлөөлөлгүйгээр илрэн гардаг бөгөөд өгүүлбэр зүйг сурах явцыг хянахад хэцүү иймээс эх хэл болон сурч буй хэлний өгүүлбэр зүйн адил талыг сайн ойлгуулж харуулах шаардлагатай. Энэхүү судалгааны ажил нь хятад хэл суралцагч монгол оюутны хувьд хятад хэлийг сурахад гаргадаг алдаанд нөлөөлөх хүчин зүйл шалтгааныг илрүүлж, алдааг тодорхойлон, алдааг сургалтын идэвхтэй аргаар багасгах боломжтой эсэх талаар судлах чиглэлтэй. Иймээс хятад хэл суралцагч оюутны гаргаж буй хятад хэл суралцах үед гаргаж буй алдаанд нөлөөлөх гол хүчин зүйлийн шалтгаан нөлөө байгааг тогтоохыг эрмэлзсэн. Үүнд: Эх хэлний нөлөө, хоёрдахь хэлний нөлөө багтана.

Эх хэлний нөлөөллийг гадаад хэлний сургалтанд харгалзан үзэхэд Монгол хэл нь залгамал бүтэцтэй хэл учраас монгол хэлний эхийн нэгжүүд бүтэц, хэлбэр, агуулга, хэрэглүүрийнхээ хувьд хятад хэлнээс өөр. Монгол хэлний нэр үгийн холбоос болон үйл үгийн хувирал нь үгийн төгсгөл нь хувирах зарчимтай бөгөөд эгшиг зохицох ёсонд захирагддагаараа хятад хэлнээс ялгаатай. Монгол хэл Алтай язгуурын ерөнхий шинж болох SOV / өгүүлэгдэхүүн-тусагдахуун-өгүүлэхүүн/ гэсэн дарааллаар өгүүлбэр бүтнэ.

Харин хятад хэл нь SVO /өгүүлэгдэхүүн-өгүүлэхүүн-тусагдахуун/ гэсэн дараалалтай байдаг онцлогийг анхааран эх хэл болон сурч буй хэлэнд байдаг төстэй үзэгдлийг хэтрүүлэн /over-generalization/ хэрэглэх явдлаар тайлбарлагддаг алдааг гаргаж байна. Энэ байдал нь хятад хэлээр өгүүлбэр зохиох, зохион бичлэг бичих үед түлхүү хэрэглэгдэн алдаа гаргах шалтгаан болдог. Эх хэлний нөлөөллийн асуудлыг 1990-ээд оноос хойш Л.Селинкер, С.Гасс, Т.Одлин, Э.Келлерман, М.Шарвуд-Смит, К.Фаерх, Ж.Каспер, Х.Рингбом, Р.Эллис нар голлон судалсан.

Судлаач Э.Келлерман суралцагч өөрийн эх

хэл, сурах гэж буй хэл хоёрын хоорондын ялгааг хэрхэн хүлээн авч мэдэрч буйг психотипологи буюу psychotypology гэж нэрлэсэн байна. Энэ нь суралцагч эх хэл, сурч буй хэл хоёрыг төсөөтэй гэж хэт их найдсанаар эх хэлний хэлзүйн мэдлэгийг ашиглан гадаад хэлээрээ харилцаанд оролцохыг чухалчлан алдаа гаргадаг гэж үзсэн байна. Судлаач Т.Одлин эх хэлнээс гадаад хэл рүү шилжих шилжилт нь авиа, морфем, үг, өгүүлбэр, утга зэрэг бүх түвшинд илэрдэг бөгөөд хэмжээ нь янз бүр байдаг гэж үзжээ.

Судлаачдын тодорхойлсоноор хүн төрөлх хэлээрээ бичвэрийг уншиж ойлгохоос илүү сонсож ойлгох чадвар хөгжсөн байдаг бол гадаад хэл /L2/ сурахад эсрэгээрээ байдаг. Энэ тодорхойлолтоос харвал гадаад хэл эхлэн суралцагчдын хувьд энэ алдаа их гардаг нь харагдаж байна. Хоёрдах хэлний нөлөөлөл нь суралцаж байгаа хэлний системээс шалтгаалан алдаа гаргадаг ба энэ алдааны шалтгаан нь өмнөх үеийн хэл сурсан туршлагаас гараагүй харин суралцагч шинэ хэлний системд суралцан өөрийн болгон турших явцад гарах алдаа юм.

Судлаач Р.Эллис үзэхдээ суралцагчийн гаргаж байгаа алдаа нь түгээмэл зүйл нь бидний үзэж байгаагаар хамгийн чухал байна. Учир нь суралцагчийн хэл эзэмших хүсэл эрмэлзлэл чармайлт нь бүх сурах үйл явцын үндэс суурь болно. Алдаа гарах эдгээр бодит шалтгаанаас гадна суралцагчийн мэдлэгийн хоцрогдол, анхаарал сарних, нэг талыг хэт барих, хичээлд хайхрамжгүй анхааралгүй оролцох, сурах зорилгоо тодорхойлж чадаагүй, суралцах сургалтын орчин анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, багш суралцагчийн харилцаа, харилцан ойлголцол, суралцагч хоорондын нөлөөлөл, багшийн заах арга барил, мэдлэг туршлага, даалгавар өгөх арга барил, түүний хүнд хөнгөний ялгамж, их багын хэмжээ гэх мэт хүчин зүйлийн нөлөөлөл зэргээс алдаа гардаг.

Алдаа гаргахад шууд бусаар нөлөөлж байгаа нөлөөллийг авч үзвэл суралцах сургалтын орчин анги танхим, сургалтын хэрэглэгдэхүүн, ном сурах бичиг, багш суралцагчийн харилцаа, харилцан ойлголцол, суралцагч хоорондын нөлөөлөл, багшийн заах арга барил, мэдлэг туршлага, даалгаврын хэмжээ зэрэг хүчин зүйл ордог байна.

Хэл шинжлэлийн шинжлэх ухааны бүтцийн ангиллаар хятад хэл бол язгуур буюу үет хэлний бүлэгт хамаарах өвөрмөц хэл юм. Гарал үүслийн ангиллаар Хятад-төвд хэлний бүлд хамаарна. Энэ язгуурт хятад, бирм, төвд зэрэг зүүн Азийн 300 орчим хэл багтах ба дотроо Хятад хэл, Төвд-Бирм хэлний хоёр бүлэгт хуваагдана.

Бидний ажигласнаар Монгол хэл, хятад хэл хоёрын бүтэц эрс ялгаатай тул алдаа их гардаг мөн хоёр хэлний ухагдахуун ялгаатай ялангуяа үгийн утга болон хэл зүйн талаар ялгаатайгаас, монгол хэлэнд ханз үсэг гэж байдаггүйгээс ихэвчлэн алдаа гардаг байна. Хятад хэл суралцагчдын хувьд 1, 2, 3, 4 ангийн суралцагчдын хувьд

хятад хэл суралцах явцдаа дараах алдаануудыг зонхилон гаргаж байгаа нь харагдсан. Үүнд: I курсийн суралцагчдын хувьд: Монгол хэлэнд дөрвөн хөг гэж байхгүй болохоор суралцагчид хөгийг бүрэн зөв эзэмшихэд хүндрэл их гардаг. 4-хөгийн дуудлага нь 51 буурах дуудлага, авиалахад харьцангуй хялбар байдаг. Тиймээс монгол суралцагчид уншлагын дунд ихэнх үсгийг 4-р хөгөөр дууддаг. Жнь: /买/-худалдаж авах гэсэн үгийг 4-р хөг болгон дуудвал /卖/-зарах гэсэн утгатай болж хувирдаг.

Хятад хэлний олон дуудлагатай үг нь өөр орчин нөхцөлд өөр дуудлагаар хэрэглэдэг. Олон дуудлагатай үгийн зөв дуудахын тулд түүний үгийн байрлал, өмнө хойнох үгийг үндэслэлийг тодорхойлдог. Хятад хэлийг анхлан суралцагчдын хувьд олон дуудлагатай үгийн нэг л дуудлагыг цээжилдэг. Ямар ч орчин нөхцөлд тэр дуудлагыг хэрэглэдэг. Ингээд авианы алдаа маш ихээр гардаг байна.

II курсийн суралцагчдын хувьд үгийн хэрэглээний тал дээр алдааг голлон гаргаж байна. Хятад хэл суралцагч оюутнуудын хувьд төрөлх хэл нь монгол хэл учраас алдаа үгийн буруу хэрэглээний алдаа нэлээд тохиолдоно. Учир нь монгол хэл нь бүрэн цогц хэл зүйн айтай бөгөөд үгийн аймгийг амархан ангилах боломжтой байдаг. Ижил дуудлагатай ханз үсгийг буруу хэрэглэх алдаа их байдаг. Жнь: 共-、公、工、攻、供、功、宫、恭-gong (эдгээр үгс бүгд ижилхэн дуудлагатай) үгийн утгыг ялгаж ойлгоход ханз үсгийн талаарх мэдлэг зайлшгүй шаардлагатай.

II курсийн суралцагчдын хувьд үйл үгийг буруу хэрэглэх алдааг гаргаж байна. Хятад хэл суралцагч оюутнууд үйл үгийн утгыг оновчтой ойлгож, сурах нь хамгийн чухал байдаг. Хятад хэл суралцагчид үйл үгийг буруу хэрэглэх тохиолдол нь нэр үг болон үйл үгийг буруу хэрэглэх, үйл үг болон тэмдэг нэрийг буруу хэрэглэх, холбох үйл үгийг буруу хэрэглэх, үгийн утгыг тодорхой ойлгоогүйгээс үүдэн буруу хэрэглэх, төрөлх хэлний үйл үгийг хятад хэлний үйл үгийн буруу хэрэглээний алдаанууд голчлон тохиолдож байна. Жнь: “掉”-diao、“摔”-shuai –нь хоёулаа “унах” гэсэн утгатай. Гэвч хэрэглээ нь ялгаатай. “掉”-diao-нь өлгөөтэй байсан зүйл унах үед хэрэглэдэг, харин “摔”-shuai-г халтиргаатай байснаас унах үед хэлдэг.

Суралцагчид хятад хэлээр сэтгэх биш харин монголоор сэтгэж өгүүлбэрээ зохиогоод дараа нь хятадаар орчуулдаг байна. Ингэж хятад хэлний үгсийн дарааллын дүрмийг эвдэж хэлний зүйн алдаа гаргадаг байна.


Судалгааны үр дүн: Бид хятад хэлний хичээлийг сонирхолтой, сургалтын идэвхтэй аргаар зохион байгуулж тэдний хятад хэл сурах идэвхийг өрнүүлэх, хичээлийн оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдын авиа зүй, өгүүлбэр зүй, хэл зүйн алдааг багасгах боломжтой эсэх талаар судлах зорилгоор дараах сургалтын идэвхтэй аргуудыг хичээл сургалтанд хэрэглэсэн. Үүнд: Бүтээлч арга, ханз бүтээх, хайчилбар хийх,

өнгийн шоо ашиглах, үгэн карт хийх, ханзны бүтэцийг сонирхолтой аргаар таниулах, дүрс бичлэг үзүүлэх, ном ашиглах, урамшуулах арга, “Од”-оор шагнах, шилдэг сурагчийг шагнах, тоглоомын арга, үгийн сүлжээ бүтээх, бинго тоглоом, “Гучин гурав” гэх мэт суралцагч төвтэй сургалтын аргуудыг ашиглав.

Дээрх сургалтын аргуудаар Ховд Их Сургуулийн хятад хэлний орчуулагч мэргэжлийн 3, 4-р ангийн нийт 21 суралцагчийн хүрээнд хятад хэлний ярих, сонсох дадлага хичээлийг 2018 оны 09 сараас 2019 оны 05 сар хүртэлх хугацаанд хятад хэлний унших, бичих дадлага хичээлийг зохион байгуулж туршилт явуулсан болно. Хичээл эхлэхээс өмнө тодорхой сэдвийн хүрээнд 150 ханз үсэгтэй зохион бичлэг найруулан бичүүлж ажиглалт, дүн шинжилгээ хийхэд нийт суралцагчдын ойролцоо утгатай үгийн сонголтын алдаа 36%, өгүүлбэр зүйн алдаа 29%, хөгийг буруу бичсэн алдаа 41%, үйл үгийн хэрэглээний алдаа 18% тус тус эзэлж байв. Харин хичээлийн төгсгөлд дахин ижил хэлбэрээр шалгалт авахад өгүүлбэрзүйн алдаа 8%-иар, хөг буруу бичих алдаа 5%-иар, үйл үгийн хэрэглээний алдаа 9%-иар, ойролцоо утгатай үгийн сонголтын алдаа 7%-иар тус тус буурсан үзүүлэлт гарсан.

Туршилтын хичээлийг эхлэхээс өмнө суралцагчдын хятад хэлний хичээлийн сонирхол, хятад хэлний хичээлд хандах хандлагыг судлах зорилгоор 10 асуулт бүхий асуулгын судалгааг 2019 оны 10 сард авсан. Мөн 2019 оны 5 сард дахин судалгаа авч хэр өөрчлөлт гарсныг харьцуулж үзлээ. 10-р сарын эхний судалгаанд 34 суралцагчийн 18 нь хятад хэлний хичээлд сонирхолгүй, 15 нь сурахад хэцүү, 6 нь сонирхолтой, 5 нь сурахад амархан гэж хариулж байсан бол дараагийн судалгаанд хичээлд сонирхолтой суралцагчдын тоо 13-аар өссөн, сонирхолгүй суралцагчийн тоо 10-аар буурсан, сурахад хэцүү гэж боддог суралцагчийн тоо 8-аар буурсан, сурахад амархан гэж үздэг нь 3-аар өссөн байна.

График-1. Туршилт хичээлийн үр дүнг харуулсан байдал.



2019 оны 12 сарын хөндлөнгийн шалгалтаас эхлэн жилийн эцсийн шалгалт хүртлэх хугацаанд гарсан үр дүнг сурлагын амжилт, чанарт гарсан өөрчлөлт, суралцагчдын хятад хэлэнд хандах хандлага гэсэн хоёр хэлбэрээр дүгнэсэн.

Дүгнэлт:

1. Суралцагчид хятад хэлийг сурах явцад үг зүй, өгүүлбэр зүйн алдаа их гаргаж байна. Энэ нь суралцагчид хятад хэлээр сэтгэх биш харин монголоор сэтгэж өгүүлбэрээ зохиогоод дараа нь хятадаар орчуулдагтай холбоотой. Бидний туршилт сургалтаар хятад хэлний сургалтанд сургалтын орчин үеийн идэвхтэй аргуудыг хэрэглэхэд тэдний сурах идэвхийг өрнүүлээд зогсохгүй гаргах алдааг багасгах боломжтой болох нь харагдаж байна.
2. Хятад хэлний ангиудын хөндлөнгийн шалгалтын амжилт 4 сараар 7%, хагас жилээр 26%-р, чанар 21%-р өссөн байна.
3. Сурлагын амжилт, чанар төдийгүй хятад хэлэнд хандах хандлага сайжирах байдал ажиглагдсан. Цөөн тооны казак оюутнуудын хувьд монгол хэлийг сайн эзэмшээгүйн улмаас хятад хэлэнд хандах хандлага сул байсан ч сурч чадахгүй, хятад хэл хэцүү гэсэн хандлага тодорхой хэмжээгээр өөрчлөгдсөн нь судалгаагаар харагдаж байна.

A POSSIBILITY FOR REDUCING MISTAKES MADE WHILE LEARNING CHINESE THROUGH ACTIVE TRAINING METHODS

Abstract

From September 2018 to May 2019, a total of 21 3rd and 4th grade Chinese translators at Khovd University practiced Chinese speaking and listening practice by reading and writing Chinese language practice. Before the lesson, 150 kanji letters were written on a specific topic and 36% of the students chose words with similar meanings, 29% with grammatical errors, 41% with humor errors, and 18% with verb usage errors. was. At the end of the lesson, however, the same test was used to reduce grammatical errors by 8%, spelling errors by 5%, verb usage errors by 9%, and similar word selection errors by 7%.

Ном зүй

- Brown, D. (2007). Principles of language learning and teaching. fifth edition: Pearson education p-324.
- L, S. (1974). Error analysis perspectives on second language acquisition. longman: p-31-54.
- R, E. (1997). SLA Research and language teaching . Oxford: p-15.
- Д, Б. (2016). Хэл шинжлэлийн удиртгал. УБ: х-287.
- Д, Н. (2017). Гадаад хэл сурч, эзэмших сэдэл тэмүүллийг чиглэсэн зорилготой өрнүүлэх асуудалд. Гадаад хэл заах арга зүйн асуудал, х-30.
- Р, Э. (2016). Англи хэл суралцагчийн хэлзүйн хэрэглээний алдааг засах арга зүйн судалгаа. УБ1: х-38.
- 刘洋. (2013). 蒙古国留学生汉字书写偏误分析及教学建议.
- 卢福波. (2011). 对外汉语教学实用语法. 北京.
- 张西平. (2009). 世界汉语教学史. 北京.
- 张静竖. (1992). 现代汉语教学. 北京.